




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2025 XII

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.1212.mn

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	3
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	3
I	Эрүүл мэнд	5
II	Нийгмийн даатгал	8
III	Нийгмийн халамж	11
IV	Гэмт хэрэг	12
V	Дүүргийн төсөв	15
VI	Хэрэглээний үнэ	18
VII	Цаг уур, агаарын бохирдол, аюулт үзэгдэл	22
VIII	Хөдөө аж ахуй	24
IX	Захиргааны мэдээ	26

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023	2024	2025	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	4 806 ^{↑129}	4 866 ^{↓12}	5 059 ^{↑40}	4 800 ^{↓51}	4 588 ^{↓44}	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	25 115 ^{↑196}	25 265 ^{↑06}	2 112 ^{↓916}	1 820 ^{↓138}	4 480 ^{↑25**}	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	2 045 ^{↑239}	3 179 ^{↑554}	3 974 ^{↑250}	5 101 ^{↑284}	5 465 ^{↑71}	
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	14.8 ^{↑129}	12.9 ^{↓1.9}	8.6 ^{↓43}	9.1 ^{↑05}	7.6 ^{↓15}	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	2 849 ^{↑13}	3 141 ^{↑102}	3 466 ^{↑103}	3 390 ^{↓22}	3 545 ^{↑46}
	Юань (БНХАУ)	Төгрөг	442 ^{↑83}	466 ^{↑54}	490 ^{↑52}	471 ^{↓39}	493 ^{↑47}
	Рубль (ОХУ)	Төгрөг	39 ⁰⁰	47 ^{↑205}	41 ^{↓128}	37 ^{↓98}	43 ^{↑162}
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	298.8 ^{↑25**}	324.9 ^{98.7}	481.4 ^{↑48.2}	456.6 ^{↓5.1}	519.7 ^{↑138}	
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум Төгрөг	169.9 ^{↑61.4}	214.0 ^{↑25.9}	438.0 ^{↑20**}	491.0 ^{↑12.1}	526.0 ^{↑7.1}	
Агаарын дундаж температур	°C	-15.6	-20.6	-19.1	-16.7	-18.5	

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024						2025			
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	349	Баянгол	8 579	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59
			Чингэлтэй	1 526	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47
			Сүхбаатар	679	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	12	Багахангай	27	Баянзүрх	9	14	Багахангай	31	Сонгино-хайрхан	11
			Багануур	21	Сүхбаатар	7		Налайх	17	Баянгол	10
			Баянгол	11	Налайх	6		Сүхбаатар	15	Хан-Уул	8
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	125	Баянзүрх	118	Хан-Уул	73	212	Баянзүрх	228	Сонгино-хайрхан	143
			Сүхбаатар	93	Налайх	73		Багануур	210	налайх	78
			Чингэлтэй	84	Багахангай	20		Хан-Уул	169	Багахангай	62
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	67	Баянгол	104	Багахангай	82	71	Баянзүрх	118	Налайх	79
			Сүхбаатар	102	Налайх	75		Хан-Уул	115	Багануур	79
			Чингэлтэй	102	Багануур	29		Чингэлтэй	109	Багахангай	23
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	300	Сүхбаатар	468	Сонгино-хайрхан	175	300	Сүхбаатар	533	Багануур	189
			Чингэлтэй	365	Багануур	108		Чингэлтэй	417	Налайх	117
			Баянгол	361	Багахангай	68		Хан-Уул	315	Багахангай	96

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м

Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII

Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй

* урьдчилсан гүйцэтгэл

** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/ Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

2025 онд 4563 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 180(3.8%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2025 онд 4563 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 180(3.8%) төрөлтөөр буурсан байна. 2025 онд эхийн эндэгдэл 2

гарсан бол нялхсын эндэгдэл 17 хүүхдээр буурч, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 хүүхдээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ

Үзүүлэлт	2023 I-XII	2024 I-XII	2025 I-XII	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	5 023	4 743	4 563	-3.8
Амьд төрсөн хүүхэд	5 059	4 800	4 588	-4.4
Эхийн эндэгдэл	1	0	2	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	37	53	36	-32.1
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	6	10	66.7

ЗУРАГ 1. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



Дүүргийн хэмжээнд 2025 онд 4480 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2660(1.5 дахин) хүнээр , 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 95.3 продицимилээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 13.8 хувийг салхин цэцэг, 3.9


хувийг гар хөл, амны өвчин, 3.2 хувийг цусан суулга, 2.8 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 1.9 хувийг тэмбүү, 1.3 хувийг заг хүйтэн, 50.6 хувийг улаан бурхан, 22.5 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эцэст

Төрөл	Хэмжих нэгж	2023 I-XII	2024 I-XII	2025 I-XII	Өөрчлөлт	
					тоо/нэгж	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	2 112	1 820	4 480	2 660	2.5**
	10000 хүнд	94.3	73.3	168.6	95.3	
Үүнээс:						
Вируст гепатит	тоо	24	13	19	6	46.2
	10000 хүнд	1.1	0.5	0.7	0.2	
Цусан суулга	тоо	214	255	147	-108	-42.4
	10000 хүнд	9.6	10.3	5.5	-4.8	
Улаан эсэргэнэ	тоо	142	66	84	18	27.3
	10000 хүнд	6.3	2.7	3.2	0.5	
Сальмонеллөз	тоо	28	50	59	9	18.0
	10000 хүнд	1.2	2.0	2.2	0.2	
Салхин цэцэг	тоо	915	708	672	-36	-5.1
	10000 хүнд	40.8	28.5	25.3	-3.2	
Гахайн хавдар	тоо	22	32	11	-21	-65.6
	10000 хүнд	1.0	1.3	0.4	-0.9	
Ёлом	тоо	8	20	12	-8	-40.0
	10000 хүнд	0.4	0.8	0.5	-0.3	
Гар хөл, амны өвчин	тоо	371	185	171	-14	-7.6
	10000 хүнд	16.6	7.4	6.4	-1.0	
Тэмбүү	тоо	124	111	91	-20	-18.0
	10000 хүнд	5.5	4.5	3.4	-1.1	
Заг хүйтэн	тоо	46	75	56	-19	-25.3
	10000 хүнд	2.1	3.0	2.1	-0.9	
Трихомониаз	тоо	21	19	9	-10	-52.6
	10000 хүнд	0.9	0.8	0.3	-0.5	
Сүрьеэ	тоо	163	173	130	-43	-24.9
	10000 хүнд	7.3	7.0	4.9	-2.1	
Улаан бурхан	тоо	0	0	2195	2195	100.0
	10000 хүнд	0.0	0.0	82.6	82.6	
Коронавирус – (Covid 19)	тоо	0	1	1	-	-
	10000 хүнд	0.0	0.0	0.0	-	
Бусад	тоо	34	112	823	711	7.3**
	10000 хүнд	1.5	4.5	31.1	26.6	

ЗУРАГ 2. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД



Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн

хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт

болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын орлого 679.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 0.4 хувиар буурсан байна.

2025 онд дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 679.3 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 3.0(0.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

2025 онд орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2025 онд

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт	
	2024 I-XII	2025 I-XII	2024 I-XII	2025 I-XII	Хувь	
Нийт дүн	693 325.3	682 349.9	340 043.8	679 357.7	-51.0	-0.4
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	593 292.2	577 266.0	293 508.8	560 898.8	-50.5	-2.8
Тэтгэмжийн сангийн орлого	48 614.5	51 816.1	24 602.9	59 695.3	-49.4	15.2
ҮОМШӨ-ний даатгалын орлого	32 802.8	32 180.8	2 655.9	37 551.3	-91.9	16.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	18 614.9	21 087.0	19 275.3	21 212.3	3.5	0.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	0.9	-	0.9	-	0	0


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.6 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.8 хувийг тэтгэмжийн

даатгалын санд, 5.5 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 3.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.


ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ДААТГАЛЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 23678 хүнд 287.1 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3416 хүнд 27.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1158 хүнд 9.3 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1665 хүнд 31.5 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 11507 хүнд 6.1 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 4293 хүнд 21.1 тэрбум төгрөгийг, 804 хүнд оршуулгын тэтгэмж 1.6 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.


ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 139 хүнд 1.9 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 266.5 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 307 хүнд 668.2 сая төгрөгийг тус тус олгосон байна. ҮОМШӨ-ний бусад зардалд 111 хүнд 174.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан 4597 хүнд 19.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Мөн ажил олгогч даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээнд 9.2 сая төгрөг зарцуулсан байна.

ЗУРАГ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



ЗУРАГ 6.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



ХАЛАМЖ

2025 онд нийгмийн халамжийн сангийн зарлагын 120.7(68.7%) тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгө буюу 106035 хүнд, алдарт эхийн одонгийн тусламж 3.3(1.9%) тэрбум төгрөг, насны хишиг 2.2(1.3%) тэрбум төгрөг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид

20.4(11.6%) тэрбум төгрөг, нийгмийн халамж 28.7(16.3%) тэрбум төгрөг, хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 199.8(0.1%) сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт 195.8(0.1%) сая төгрөг тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 6.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая төгрөг

Үзүүлэлт	2025 I-XII	
	Дүн	Хүний тоо
Нийт зарлагын дүн	175 857.3	187 845
Нийгмийн халамжийн сан	28 704.1	28 819
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	20 363.7	21 369
Алдарт эхийн одонгийн тусламж	3 360.7	14 397
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	195.8	675
Хүүхдийн мөнгө	120 760.3	106 035
Насны хишиг	2 257.3	14 885
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	15.6	13
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	199.8	1 652

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



ГЭМТ ХЭРЭГ

2025 онд дүүргийн нутаг дэвсгэрт 5465 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 364(7.1%) хэргээр өссөн үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, 2025 онд

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2023 I-XII	2024 I-XII	2025 I-XII	Тоо	Хувь
Дүүргийн дүн	3 974	5 101	5 465	364	7.1
Хүний амь	13	14	15	1	7.1
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	53	51	40	-11	-21.6
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	621	614	750	136	22.1
Хүчин	37	44	57	13	29.5
Хулгай	431	996	1 081	85	8.5
Малын хулгай	11	3	8	5	2.7**
Дээрэм	13	40	55	15	37.5
Залилан	2 059	2 370	2 209	-161	-6.8
Олон нийтийн амгалан тайван байдал	1		1	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	109	186	280	94	50.5
Бусад	626	783	969	186	23.8

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 40.4 хувийг залилан, 13.7 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19.8 хувийг хулгай, 5.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын

журам зөрчих, 1.1 хувийг хүчин, 1.0 хувийг дээрэм, 0.7 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 0.3 хувийг хүнийг амь, 0.2 хувийг малын хулгай, 17.7 хувийг бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ

Хэлтэс	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өөрчлөлт 2025/2024	
	2023 I-XII	2024 I-XII	2025 I-XII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	24 978	32 123	33 144	1 021	3.2
Хан-Уул дүүргийн дүн Үүнээс: Цагдаагийн хэлтсээр	3 974	5 101	5 465	364	7.1
I хэлтэс	2 598	3 282	3 189	-93	-2.8
II хэлтэс	1 376	1 819	2 276	457	25.1
Нийслэлийн дүнд эзлэх хувь	15.9	15.8	16.5	35.7	0.7

Дүүргийн хэмжээнд 2025 онд сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувь 16.5 байгаа нь өмнөх оны мөн үетэй 0.7 нэгж хувиар өссөн байна. Түүнчлэн дүүргийн

хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 58.3 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

ХҮСНЭГТ 9. ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, хэлтсээр

Хэлтэс	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг		Эмэгтэй хүн оролцсон		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	
	2024 I-XII	2025 I-XII	2024 I-XII	2025 I-XII	2024 I-XII	2025 I-XII
Дүүргийн дүн	323	351	475	722	109	124
I хэлтэс	168	167	333	522	64	59
II хэлтэс	155	184	142	200	45	65

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2025 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 124 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 15(12.1%) хэргээр өссөн байна. Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 5219 иргэн хохирсоны 2439(46.7%) нь эмэгтэйчүүд байсан бол 16 (0.3%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 93(1.8%) нь 8-13 насны хүүхэд, 170(3.3%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 859 хүн гэмтэж осолдон, 72 хүн нас барж, төр, ард иргэдэд 190.5 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 99.3(52.1%) тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2025 онд тус дүүргийн 15 дугаар хороонд 646 гэмт хэрэг гарч хамгийн өндөр, 7 болон 13 хороодын нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 44 гэмт хэрэг гарсан байна.

ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

Хороо	Нийт дүн	Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэм	Залилан	Малын хулгай	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	Бусад
							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
Нийт дүн	5 465	15	40	750	57	1 081	861	29	53	55	2 209	8	280	1	969
1-р хороо	165		1	25	2	24	21		1	2	69		9		33
2-р хороо	205			23		53	43	2	3		86		10		33
3-р хороо	391		2	55	5	61	53	1	1	6	170		40		52
4-р хороо	282	1	1	14	2	33	24	1	4		184		20		27
5-р хороо	91	1	1	19		14	10	2			27		8		21
6-р хороо	98		1	12	2	9	5		2		44		12		18
7-р хороо	44		1	13	1	8	7			1	10		6		4
8-р хороо	171	1	3	34	7	26	11	1	1	1	41	1	22		35
9-р хороо	84		2	15	2	21	13	1		3	20		5		16
10-р хороо	128		1	21	4	29	21	1			46		12		15
11-р хороо	408	2	4	85	2	85	74		5	3	143		10		74
12-р хороо	77	1	4	20	2	19	16			1	10		8		12
13-р хороо	44	1	1	11		8	6	1			13	1	4		5
14-р хороо	117	1		26	4	41	26	1			19	6	8		12
15-р хороо	646			100	3	158	129	1	23	8	231		22		124
16-р хороо	86		1	21	1	23	15	2		1	19		9		11
17-р хороо	304		1	26	4	109	100	1		6	98		8	1	51
18-р хороо	279			21		62	59			6	124		6		60
19-р хороо	237	1	2	32		38	34		1	4	108		8		44
20-р хороо	475		4	29	3	50	48			1	298		7		83
21-р хороо	315	1	5	44	3	64	43	5	3	6	121		9		62
22-р хороо	80		1	12	2	17	15			1	25		5		17
23-р хороо	293		2	37	2	53	35	3	3		123		9		67
24-р хороо	290	4	2	39	6	48	34	1	5	3	110		14		64
25-р хороо	155	1		16		28	19	5	1	2	70		9		29




ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого 519.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 61.1 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2025 онд 519.7 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 61.1(10.5%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2024 оноос 13.8 хувиар өссөн байна. Төсвийн нийт

орлогын 97.5 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 2.5 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 506.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 66.8(11.7%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бол татварын бус

орлого 13.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 5.8(78.5%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 онд

	Төсвийн орлого			Үүнээс					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү
сая төгрөг									
Дүн	519 735.3	-10.5	-61 064.7	506 610.7	-11.7	-66 836.6	13 124.6	78.5	5 771.9

Орлогын албан татвар төлөвлөснөөс 61.7 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр,

хураамж төлөвлөснөөс 7.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн бол хөрөнгийн албан татвар 2.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 12. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 онд

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Өөрчлөлт	
	сая төгрөг		Хувь	Дүн
Орон нутгийн орлого	580 800.0	519 735.3	-10.5	-61 064.7
1.Татварын орлогын дүн	573 447.3	506 610.7	-11.7	-66 836.6
1.1 Орлогын албан татвар	487 530.0	425 854.9	-12.7	-61 675.0
Хувь хүний орлогын албан татвар	487 530.0	425 854.9	-12.7	-61 675.0
1.2 Хөрөнгийн албан татвар	25 744.8	28 127.5	9.3	2 382.7
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	60 172.5	52 628.3	-12.5	-7 544.2
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	20 265.0	17 620.3	-13.1	-2 644.7
Улсын тэмдэгтийн хураамж	15 000.0	12 887.2	-14.1	-2 112.8
Ашигт малтмал ашигласны төлбөр	265.0	157.9	-40.4	-107.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5 000.0	4 575.2	-8.5	-424.8
1.3.2 Газрын төлбөр	39 857.5	35 002.0	-12.2	-4 855.5
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	50.0	6.0	-88.0	-44.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	50.0	6.0	-88.0	-44.0
2.Татварын бус орлогын дүн	7 352.7	13 124.6	78.5	5 771.9
2.1 Нийтлэг татварын бус орлого	4 800.3	10 596.5	1.2**	5 796.2
Торгуулийн орлого	4 000.0	9 620.6	1.4**	5 620.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	759.1	910.1	19.9	151.0
Бусад орлого	41.2	65.8	59.7	24.6
2.2 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2 552.4	2 528.1	-1.0	-24.3

ЗУРАГ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 13.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 онд, сая төгрөг

Үзүүлэлт	Зарлага		Өөрчлөлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Дүн
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	608 293.5	526 051.0	-13.5	-82 242.6
1. Урсгал зарлага	537 101.6	488 254.3	-9.1	-48 847.3
1.1 Бараа, үйлчилгээний зардал	136 564.6	111 561.0	-18.3	-25 003.6
Цалин хөлс	19 433.7	15 246.8	-8.1	-489.1
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	2 429.2	1 716.0	-29.4	-713.2
Бараа, үйлчилгээний бусад зардал	114 701.7	94 598.2	-18.3	-1 301.4
1.2 Татаас ба урсгал шилжүүлэг	306 911.8	276 415.9	-9.9	-30 495.9
Татаас	-	-	-	-
Урсгал шилжүүлэг	306 911.8	276 415.9	-9.9	-30 495.9
2. Хөрөнгийн зардал	71 192.0	37 796.7	-46.9	-33 395.3
Барилга байгууламж	28 806.4	15 831.1	-45.1	-12 975.3
Тоног төхөөрөмж	2 097.6	1 434.7	-31.6	-662.8
Бусад хөрөнгө	40 288.0	20 530.8	-49.0	-19 757.2

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн

сарын эхэнд үлдэгдэлгүй байсан бол шинээр өглөг үүсээгүй байна.

ХҮСНЭГТ 14.

ӨГЛӨГ, 2025 онд

	12-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	12-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	0.0	0.0	0.0	0.0

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өссөн байна.

Нийслэлийн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс 2025 онд өмнөх оны мөн үеэс 7.6 хувь, өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2025 оныг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 7.6 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 11.9 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис бүлгийн үнэ 9.5 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 6.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 5.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 8.3 хувь, тээвэр бүлгийн үнэ 0.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний

бүлгийн үнэ 6.9 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 13.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 7.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 9.2 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 12.6 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 15. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2024-XII 2023-XII	2025-XII 2024-XII	2025-XII 2024-XII	2025-XII 2025-XI
Ерөнхий индекс	8.6	9.1	7.6	0.3
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	12.6	8.4	11.9	1.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	4.6	3.5	9.5	2.6
Хувцас, бөс бараа, гутал	6.6	10.1	6.7	0.4
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	6.3	24.9	5.9	0.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	6.3	9.0	8.3	0.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	8.0	5.2	6.9	0.7
Тээвэр	0.4	2.6	0.5	-1.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.2	2.2	2.5	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.4	5.5	7.6	0.0
Боловсролын үйлчилгээ	21.2	19.7	13.6	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	17.5	9.3	9.2	0.1
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	2.8	2.3	6.1	0.0
Бусад бараа, үйлчилгээ	22.4	8.7	12.6	1.4

2025 онд үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 418 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 142(34.0%) бараа үйлчилгээний үнэ өсөж, 44(10.5%) бараа үйлчилгээний үнэ буурч, 232(55.5%) бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.

2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний сонгогдсон 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад элсэн чихэр 3688 төгрөг, польш алим 3500 төгрөг, “Хонины мах”, ястай 2500 төгрөг, төмс 1900 төгрөг, “Үхрийн мах”,


ястай мах, сонгино тус бүр 1500 төгрөг, тараг, цөцгийтэй, “Сүү” ХК-ийн 610 төгрөг, дээд зэргийн гурил 600 төгрөг, Талх чихэр” ХК-ны “Атар” талх 480 төгрөг, 2-р зэргийн гурил 220 төгрөг, 1-р зэргийн гурил 140 төгрөгөөр тус тус өссөн бол, манжин 1000 төгрөг, задгай сүү 100 төгрөгөөр буурсан байна. Харин байцаа болон цагаан будаа, лууван үнэ тогтвортой байна.

ХҮСНЭГТ 16. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, ТӨГРӨГ, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2024 XII	2025 XII	Хувь
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	ширхэг	2 400	2 880	20.0
Хонины мах, ястай	кг	13 000	15 500	19.2
Үхрийн мах, ястай	кг	19 000	20 500	7.9
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	3 050	3 650	19.7
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	кг	2 660	2 800	5.3
Гурил ,2-р зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	1 830	2 050	12.0
Элсэн чихэр	кг	5 612	9 300	65.7
Төмс, монгол	кг	1 400	3 300	2.3**
Байцай, монгол	кг	2 800	2 800	0.0
Лууван, монгол	кг	3 000	3 000	0.0
Манжин, монгол	кг	4 500	3 500	-22.2
Сонгино, хятад	кг	3 500	5 000	42.9
Цагаан будаа	кг	6 610	6 400	-3.2
Алим, Польш	кг	8 000	11 500	43.8
Сүү, задгай	литр	4 100	4 000	-2.4
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	4 140	4 750	14.7

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


ЗУРАГ 11. НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ, ТӨГРӨГ



ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн эцэст, төгрөг



ЗУРАГ 13. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн эцэст, төгрөг



ХҮСНЭГТ 17. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2024.XII.19					2025.XII.20				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Дундаж үнэ	3 910	-	2 390	3 140	1 790	3 643	-	2 590	3 140	1 950
Петровис	3 910	-	2 390	3 140	-	3 610	-	2 590	3 140	-
Магнай трейд	3 910	-	2 390	3 140	-	3 710	-	2 590	3140	-
Шунхлай	3 910	-	2 390	3 140	-	3 610	-	2 590	3140	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 950

Эх үүсвэр: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 12 дугаар сарын мэдээ

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

- I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
- t – Тайлант үе
- 0 – суурь үе
- P_t^i – i барааны тайлант үеийн үнэ
- P_0^i – i барааны тайлант үеийн үнэ
- q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 12 дугаар сард -18.5 °C байв.

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 12 дугаар сард -18.5 °C байгаа нь өмнөх оны мөн үеийн дундажтай харьцуулбал 1.8°C-аар хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм -4.4°C,

хамгийн хүйтэн хэм -28.8°C, хур тунадасны нийлбэр 1.2 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 10 метр секунд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 18.

АГААРЫН БОХИРДОЛТ, XII сард

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий, мг/м ³	SO ₂	0.050	415	0.107	137	0.034
Азотын давхар исэл, мг/м ³	NO ₂	0.050	427	0.242	285	0.043
Тоосжилт, мг/м ³	PM ₁₀	0.100	487	0.288	228	0.088
	PM _{2.5}	0.050	478	0.172	354	0.064
Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м ³	CO	10.000	369	7.758	64	1.557
Озон, мг/м ³	O ₃	0.100	687	0.08	21	0.007

2025 оны 12 дугаар сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад азотын давхар исэл 0.014 мг/м³ -ээр, PM 10 тоосонцор 0.042 мг/м³-

ээр, PM 2.5 тоосонцор 0.034 мг/м³ -ээр, их, нүүрс төрөгчийн дутуу исэл 0.952 мг/м³ -ээр, озон 0.009 мг/м³-ээр тус тус их, хүхэрлэг хий 0.086 мг/м³-ээр бага байна.

ХҮСНЭГТ 19. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м3, XII сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв			Богд хааны ордон музей			Нисэх		
		2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.047	0.05	0.034	0.030	0.039	0.041	-	-	-
	Хамгийн их	0.107	0.09	0.058	0.067	0.01	0.086	-	-	-
	XXX*-с давсан %	39	45	10	3	44	33	-	-	-
	Хэмжилтийн тоо	31	31	31	31	27	30	-	-	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.052	0.036	0.044	0.046	0.051	0.057	0.056	-
	Хамгийн их	-	0.139	0.074	0.058	0.063	0.064	0.107	0.099	-
	XXX*-с давсан %	-	48	23	17	44	63	61	54	-
	Хэмжилтийн тоо	-	31	30	24	27	30	31	24	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	1.226	0.355	1.292	0.909	0.735	1.065	2.396	2.014	1.934
	Хамгийн их	5.987	2.651	4.947	8.621	2.29	2.064	14.588	4.976	3.17
	XXX*-с давсан %	-	-	7	-	-	-	4	-	-
	Хэмжилтийн тоо	92	89	29	93	93	30	93	83	31
Тоос PM ₁₀	Дундаж	0.06	0.088	0.065	0.052	0.074	0.058	0.069	0.07	0.042
	Хамгийн их	0.012	0.178	0.111	0.107	0.142	0.098	0.158	0.115	0.06
	XXX*-с давсан %	10	29	3	6	23	-	16	23	-
	Хэмжилтийн тоо	31	31	31	31	31	30	31	31	31
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.064	0.023	0.029	0.038	0.028	0.055	0.062	0.034
	Хамгийн их	-	0.14	0.044	0.071	0.085	0.059	0.11	0.108	0.05
	XXX*-с давсан %	-	48	7	16	26	23	61	68	42
	Хэмжилтийн тоо	-	31	29	31	31	30	31	31	31
Озон O ₃ **	Дундаж	0.025	0.02	0.018	-	-	-	0.023	0.024	0.08
	Хамгийн их	0.055	0.066	0.046	-	-	-	0.073	0.087	-
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	93	93	93	-	-	-	93	-	80

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.




ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хан-Уул дүүрэгт 2025 оны мал тооллогоор нийт 56651 толгой мал тоологдсон нь 2024 оноос 7188 (14.5%) толгой малаар өссөн байна.

Нийслэлийн хэмжээнд 2025 онд 423592 толгой мал тоологдсон бөгөөд 13.4 хувийг Хан-Уул дүүргийн мал эзэлж байна.

ЗУРАГ 14. ДҮҮРГИЙН НИЙТ МАЛЫН ТОО, оноор



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад, тэмээ 4 толгойгоор (14.3%) адуу 3646 толгойгоор (18.7%), үхэр 1050 толгойгоор (8.0%), хонь 1511 толгойгоор (16.8%), ямаа 977 толгойгоор (12.6%) тус тус өссөн байна.

Иргэдийн хувийн мал 55913 толгой болж, өмнөх оноос 6826 толгойгоор өссөн бол аж ахуйн нэгж, байгууллагын мал 738 болж өмнөх оноос 362 толгойгоор өссөн байна.

ХҮСНЭГТ 20. МАЛЫН ТОО, төрлөөр

Малын төрөл	2020	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт	
							Тоо	Хувь
Малын тоо, бүгд	46 090	42 867	46 068	52 083	49 463	56 651	7 188	14.5
Тэмээ	7	11	19	8	28	32	4	14.3
Адуу	11 960	12 597	15 422	18 052	19 529	23 175	3 646	18.7
Үхэр	11 900	11 214	12 293	12 481	13 158	14 208	1 050	8.0
Хонь	10 231	9 626	9 158	10 867	8 990	10 501	1 511	16.8
Ямаа	11 992	9 419	9 176	10 675	7 758	8 735	977	12.6
Хонин толгойд шилжүүлснээр*	176179	173621	199223.4	221764.5	231763.2	265995.5	34232.3	14.8

* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

2025 онд Хан-Уул дүүргийн 12-р хорооны мал 9.8 хувиар, 13-р хорооных 15.7 хувиар, 14-р хорооны мал 14.6 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 21. МАЛЫН ТОО, хороогоор

Хороо	2024	2025	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт, хувь
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Дүн	49 463	56 651	32	23 175	14 208	10 501	8 735	14.5
12-р хороо	3743	4111	3	1474	1642	273	719	9.8
13-р хороо	13 392	15 498	-	3827	6630	2612	2429	15.7
14-р хороо	32 328	37042	29	17874	5936	7616	5587	14.6

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 37042 толгой малаар 14-р хороо тэргүүлсэн бол хамгийн цөөн малтай нь 12-р хороо 4111 толгой малтай байна. 2025 онд нийт мал сүргийн 34.0 хувийг бог мал, 66.0 хувийг бод мал эзэлж байна. Нийт мал сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр нь дараах хүснэгтэд харууллаа.

Мал төллөлт, төл бойжилт: 2025 онд 16665 хээлтэгч мал төллөж, 16665 төл гарсны 16460 төл (98.8%) нь бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 4313 толгойгоор (35.5%) өссөн.

ЗУРАГ 15. БОЙЖУУЛСАН ТӨЛ, оноор



Бойжуулсан нийт төлийн 29.8 хувийг унага, 34.5 хувийг тугал, 18.8 хувийг хурга, 16.9 хувийг ишиг эзэлж байна.

2025 оны мал тооллогоор нийт 16665 гарсан төлийн 205 (1.2%) толгой нь хорогдож, төл бойжилт 98.8 хувьтай байна. Хорогдсон төл малын тоо 2024 оныхоос 627 толгойгоор буурсан. Нийт хорогдсон төлийн 26.8 хувийг унага, 33.7 хувийг тугал, 18.0 хувийг хурга, 21.5 хувийг ишиг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол: Оны эхний малын 1.1 хувьтай тэнцэх 524 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 4490 толгойгоор буурсан. Хорогдсон нийт малын 26.3 хувийг адуу, 24.4 хувийг үхэр, 19.5 хувийг хонь, 29.8 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 9 толгой (1.7%) мал өвчнөөр хорогджээ.

ХҮСНЭГТ 22. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Үзүүлэлт	2024	2025	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	5014	524	-	138	128	102	156
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	4	9	-	5	1	2	1

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2025 онд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 4913 өргөдөл, гомдол ирүүлснээс 4830 (98.3%)-ийг шийдвэрлэн

хуулийн дагуу хугацаанд хариу өгч, шийдвэрлэх хугацаа болоогүй 82 (1.6%), хугацаа хэтэрсэн 1 (0.02%) өргөдөл гомдол байна.

ХҮСНЭГТ 23. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ-ЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Өргөдөл, гомдлын агуулга	Өргөдөл гомдлын тоо	АГУУЛГА					Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл			
НИЙТ ДҮН	4 913	2 972	1 559	325	53	4	4 830	82	1
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	158	96	43	17	2		155	3	
Санхүү төрийн сангийн хэлтэс	7	5	2				7		
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	63	35	21		7		62	1	
Нийгмийн хөгжлийн хэлтэс	19	10	7	2			19		
Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	361	149	199		13		357	4	
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	262	132	129		1		258	4	
Хууль, эрх зүйн хэлтэс	34	17	13			4	33	1	
Архивын хэлтэс	28	28					28		
Цэргийн штаб	123	123					123		
ЗДТГ-ын дүн	1 055	595	414	19	23	4	1 042	13	0
Насан туршийн суралцахуйн төв	33	33					33		
Боловсролын хэлтэс	514	75	387	39	13		508	6	
Газар зохион байгуулалтын алба	1560	1 248	296	2	14		1527	32	1
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс	132	122	10				129	3	
Нийгмийн даатгалын газар	94	42	51	1			93	1	
Татварын хэлтэс	680	653	26	1			672	8	
Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс	231	165	59	7			228	3	
Улсын бүртгэлийн хэлтэс	42	6	26	9	1		42		
Цагдаагийн 1-р хэлтэс	385	18	162	204	1		374	11	
Цагдаагийн 2-р хэлтэс	187	15	128	43	1		182	5	
Дэргэдэх хэлтэс, албадын дүн	3 858	2 377	1 145	306	30	0	3 788	69	1

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	
I	Эрүүл мэнд	Ц.Энх-Оюун
II	Нийгмийн даатгал	Т.Баттулга
III	Нийгмийн халамж	Т.Баттулга
IV	Гэмт хэрэг	Б.Тодмаа
V	Төсөв	Ж.Энх-Амгалан
VI	Хэрэглээний үнэ	Ж.Энх-Амгалан
VII	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	Ж.Энх-Амгалан
VIII	Захиргааны мэдээ	Ж.Энх-Амгалан